

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ**Санамж:**

- a. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.**
b. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Монгол орны нутгаас олдсон Доод Палеолитийн үеийн хамгийн эртний дурсгалын нэг Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг Уранхайрхан уулын орчим нийт 47 бууц, суурин бүхий дурсгал дотроос хамгийн эртний бууцыг хэрхэн нэрлэсэн бэ? **(2 оноо)**

- A. Уранхайрхан 15Б В. Нарийн гол 17Б С. Цагаан агуй 16Б
D. Ярх уул 13Б Е. Өлзийт 11Б

2. Хуучин чулуун зэвсэг (Палеолит)-ийн Дунд үе (100000-40000)-ийн хүмүүс ямар зэвсгийг голлон хэрэглэж байсан бэ? **(1 оноо)**

- A. Нүдүүр, нухуур маягийн зэвсэг В. Цуулах болон холтчин ирлэсэн зэвсэг
C. Гилбэр ба үзүүр мэсэн зэвсэг D. Гурвалжин мэс ба хянгар зэвсэг
E. Харвах, намнах зориулалт бүхий зэвсэг

3. Монгол нутагт амьдарч байсан эртний хүмүүс хэдий үеэс гал гарган хэрэглэх болсон бэ? **(1 оноо)**

- A. Доод Палеолитийн үе В. Дээд Палеолитийн үе
C. Дунд Палеолитийн үе D. Мезолитийн үе E. Неолитийн үе

4. Хөдөлмөрийн хуваарь бий болж, шүтлэг бишрэлийн эх суурь Шинэ чулуун зэвсэг (Неолит)-ийн үед бий болсон гэвэл он цагийн хувьд хэдий үед хамаарах вэ? **(1 оноо)**

- A. 40000-15000 жил В. 8000-3000 жил
C. 15000-8000 жил D. 100000-40000 жил E. 3000-2500 жил

5. Монгол нутаг дахь “Буган чулуун хөшөө”-нөө буга тураг сийлэн үлдээсний хамгийн гол шалтгаан аль нь вэ? **(2 оноо)**

- A. Хойд насны төсөөлөлтэй холбоотой учир
B. Монголчуудын шүтдэг амьтан учир
C. Монголчууд өөрсдийн гарлыг бугатай холбон үздэг учир
D. Эрхэмлэн дээдэлж, бишрэн шүтэж байсан учир
E. Монгол нутаг дахь хамгийн том амьтан учир

6. Модун, Хүннүгийн шаньюй (Хаан) болж, бүх 24 аймгаа нэгтгэн захирч Хүннү улсыг үндэслэн байгуулжээ. Энэ үйл явдал хэдэн онд болсон бэ? **(1 оноо)**

- A. НТӨ 200 он В. НТӨ 209 он С. НТӨ 198 D. НТӨ 190 E. НТӨ 189

7. ОХУ-ын Буриадын нийслэл Улаан-Үд хотоос 16 км-ын зайд, Сэлэнгэ мөрний хуучин голтригийн хөвөөнд орших Хүннү гүрний үед хамаарах суурин аль нь вэ? **(1 оноо)**

- A. Баянбулагийн туурь В. Бүрхийн дөрвөлжин
C. Тэрэлжийн дөрвөлжин D. Гуа дов E. Иволгийн балгас



8. "... Эрдэм чадал Хүннүгээс илүү, санаа бодлого үлэмж нэмэгджээ. Зэвсэг хурц, морь хурдан Хүннү нараас нэн давжээ" хэмээн аль улсын, хэн гэдэг хааны цэрэг морьдийг хэлсэн бэ? **(2 оноо)**

- A. Сяньби улсын Таньшихуай
 B. Жужан улсын Мугулюй
 C. Сяньби улсын Кэбинэн
 D. Жужан улсын Шэлүнь
 E. Түрэг улсын Буман

9. Сяньби улсын газар нутгийн баруун зах нь хаана хүрч байсан бэ? **(2 оноо)**

- A. Алтайн уул, Тэнгэр уул
 B. Алтайн нуруу, Ховд гол
 C. Хангайн нуруу, Завхан гол
 D. Алтайгаас, Дуньхуан, Үсүнь хүртэл
 E. Хангайн нурууны баруун бие

10. Сяньби нарын нэг хэсэг болох Тоба нарын Зүүн хойд Хятадыг эзлэн байгуулсан улс аль нь вэ? **(1 оноо)**

- A. Тан улс
 B. Хан улс
 C. Вэй улс
 D. Жоу улс
 E. Ляо улс

11. Жужан улс 330-555 оны хооронд оршин тогтнож байсан гэвэл энэ хэдээс хэддүгээр зуун бэ? **(1 оноо)**

- A. III-V зуун
 B. IV-VI зуун
 C. III-VI зуун
 D. IV-V зуун
 E. III-VII зуун

12. Түрэг улсын "Элтэрэс" буюу "Улсыг хураагч хаан" хэмээн алдаршсан хаан аль нь вэ? **(1 оноо)**

- A. Пэйло
 B. Күтүлүг
 C. Моюунчур
 D. Культегин
 E. Буман

13. Түрэг улсын үед холбогдох хүн чулуудын нэлээдийн толгойг нь тасдсан байх бөгөөд толгой нь бүтэн үлдсэн хүн чулуудад ямархуу төрхтэй хүнийг дүрсэлсэн хэмээн үздэг вэ? **(2 оноо)**

- A. Хятан төрхтэй хүнийг завилуулан суулгаж
 B. Түрэгжүү унжуу хамартай, ширвээ сахалтай хүнийг
 C. Уйгаржуу төрхтэй хүнийг хоёр гарт нь сав бариулан
 D. Монголжуу өргөн шанаатай, жартгар нүдтэй хүнийг
 E. Монголжуу өргөн шанаатай хүнийг исэр суудалд суулган

14. Уйгурын Яклагар овгийн ноён Пэйло өөрийн биеэ Күтүлүг Билгэ Күл хаан хэмээн өргөмжилж хаан суусан хэмээвэл хамаарах он цаг аль нь вэ? **(1 оноо)**

- A. 844 он
 B. 750 он
 C. 780 он
 D. 800 он
 E. 744 он

15. Монгол нутагт оршиж байсан эртний улсуудын нэг Хятан гүрний үед холбогдох Хэрлэн барс хотын суварга хаана байдаг вэ? **(1 оноо)**

- A. Дорнод аймаг Цагаан овоо сум
 B. Булган аймаг Дашинчилэн сум
 C. Хэнтий аймаг Баянхутаг сум
 D. Дорнод аймаг Булган сум
 E. Сүхбаатар аймаг Сүхбаатар сум

16. Дараах улсуудын аль нь эрдмийн хоёр хүрээлэн байгуулж байсан бэ? **(1 оноо)**

- A. Жужан улс
 B. Хүннү гүрэн
 C. Сяньби улс
 D. Хятан гүрэн
 E. Түрэг улс



17. Хар Хятан нар төрт улсаа дараах бүс нутгуудын алинд нь байгуулсан бэ? **(1 оноо)**

- A. Зүүн хойд Ази
D. Европ Унгарын тал
- B. Төв Ази
- C. Дундад Ази
E. Зүүн өмнөд Ази

18. “Монголын нууц товчоон”-нд өгүүлснээр “... Жамуха анд амархан уйддаг гэдэг билээ. Одоо биднээс уйдах цаг нь болсон биз” хэмээн аль аймгийн, хэн гэдэг хатан Тэмүжинд хэлсэн бэ? **(2 оноо)**

- A. Татар аймгийн Есүй хатан
C. Мэргэд аймгийн Хулангоо хатан
E. Тангуд улсын Гүрбэлжингоо хатан
- B. Хонгирад аймгийн Бөртэ хатан
D. Татар аймгийн Есүгэн хатан

19. Чингис хааны 1203 Хэрэйд аймгийн Тоорил хантай хийсэн тулалдаан ямар нэрээр түүхэнд тэмдэглэгдсэн бэ? **(1 оноо)**

- A. Буур хээрийн тулаан
C. Сайрь хээрийн тулаан
E. Улз голын тулаан
- B. Наху гүний тулаан
D. Муу өндөрийн тулаан

20. Чингис хаан аль улсад “Алтан аргамжаа тасдуулав” хэмээн “Монголын нууц товчоо”-нд гардаг вэ? **(2 оноо)**

- A. Тангуд улс
C. Хорь түмэд
- D. Алтан улс
- B. Сартуул улс
E. Хар Хятан улс

21. Хулгана жилийн хуран сард Хэрлэнгийн хөдөө арал, Шилхинцэг хоёрын завсар бичиж дууссан гэвэл энэ ямар зохиол вэ? **(1 оноо)**

- A. Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл
C. Цагаан түүх
- D. Судрын чуулган
- B. Монголын нууц товчоо
E. Алтан товч

22. Дөрвөн их хааныг төрүүлэн өсгөсөн, Тулуйн их хатан аль нь вэ? **(2 оноо)**

- A. Дайр Үсүний охин Хулангоо
C. Мэргэд угсааны Туракина
E. Бурхан хааны охин Гүрбэлжингоо
- B. Хутуга бэхийн охин Огул Хаймиш
D. Жаха Хамбугийн охин Сорхагтани

23. “... Тэнгэрийн байдал дулаарах тийшээ хандлаа. Эмил нутгийн уур амьсгал надад зохидог юм” хэмээн баруун зүг хөдөлсөн боловч замдаа өвчний улмаас таалал болсон хаан аль нь вэ? **(2 оноо)**

- A. Гүюг хаан
C. Мөнх хаан
- B. Өгэдэй хаан
D. Хубилай хаан
- E. Чингис хаан

24. Дараах хаадыг төр барьсан он цагтай нь зөв харгалзуулна уу? **(2 оноо)**

1. Хубилай хаан
2. Гэгээн хаан
3. Төгстөмөр хаан
4. Тогоонтөмөр хаан
- a. 1260-1294 он
b. 1333-1370 он
c. 1321-1323 он
d. 1329-1332 он

- A. 1-а, 2-б, 3-с, 4-д.
D. 1-а, 2-б, 3-д, 4-с.
- B. 1-а, 2-д, 3-с, 4-б.
- C. 1-а, 2-с, 3-б, 4-д.
E. 1-а, 2-с, 3-д, 4-б.



25. Энэхүү дурсгал хэдий үед холбогдох ямар нэртэй түүхийн дурсгал вэ?

(2 оноо)



- A. Юань улсын үеийн цаасан мөнгөний дардас
- B. Хубилай хааны тамганы дардас
- C. Юань гүрний үеийн дөрвөлжин үсэгтэй гэрэг
- D. Гүүг хааны тамганы дардас
- E. Зүрхэн тольт хэмээх зохиол

26. Хубилай хаан 8 удаа элч илгээж байсан бөгөөд 2 удаа цэрэг илгээсэн боловч эзэлж авч чадаагүй гэвэл энэ ямар улс вэ? (1 оноо)

- A. Хятад улс
- B. Вьетнам улс
- C. Япон улс
- D. Солонгос улс
- E. Бирм улс

27. XIII зууны сүүл хагаст Европоос ирж, Хубилай хааны дэргэд шадарлаж байсан бөгөөд хожим “Орчлонгийн элдэв сонин” хэмээх зохиол бичсэн жуулчин аль нь вэ? (2 оноо)

- A. Гильом Де Рубрук
- B. Марко Поло
- C. Плано Карпини
- D. Рашид-Ад-Дин
- E. Ата Малик Жувейн

28. Дараах хаадын хэн нь Гэгээн хаан хэмээх оны цол хэрэглэж байсан бэ? (1 оноо)

- A. Шадбал хаан
- B. Боди-Алаг хаан
- C. Молон хаан
- D. Дэлбэг хаан
- E. Ринчинбал хаан

29. Махахурхис хаан Монголын түүхэнд ямар хаан хэмээн алдаршсан бэ? (1 оноо)

- A. Нигүүлсэгч хаан
- B. Ухаант хаан
- C. Сэцэн хаан
- D. Хутагт хаан
- E. Үхэгт хаан

30. XVII зууны эхэн хагаст амьдарч байсан Халхын Түшээт хан аль нь вэ? (1 оноо)

- A. Шолой
- B. Ринчиндорж
- C. Субадай
- D. Дондовдорж
- E. Гомбодорж

31. Өмнөд Монгол Манжид дагаар орох Мүгдэний чуулган хэдэн онд болсон бэ? (1 оноо)

- A. 1636 он
- B. 1634 он
- C. 1632 он
- D. 1696 он
- E. 1644 он

32. Түшээт хан Чахундорж нар тэргүүлэн өөрсдийн дүү нараа хэдэн онд Манжийн хааны ордонд илгээсэн бэ? (1 оноо)

- A. 1676 он
- B. 1652 он
- C. 1661 он
- D. 1655 он
- E. 1638 он

33. Манжийн хааны оролцоотойгоор Халхын баруун, зүүн гарыг эвлэрүүлэх чуулган хэдэн онд хаана болсон бэ? (2 оноо)

- A. 1757 онд Шар бэл
- B. 1688 онд Ар элстэй
- C. 1691 онд Долон нуур
- D. 1640 онд Улаан бураа
- E. 1686 онд Хүрэн бэлчир



34. 1725 онд Түшээт хан аймгаас хэдэн хошуу тасдан нэгэн аймгийг байгуулсан гэвэл аль нь вэ? **(2 оноо)**

- A. Засагт хан аймаг
B. Сэцэн хан аймаг
C. Далай хан аймаг
D. Сайн ноён аймаг
E. Үнэн зоригт хан аймаг

35. Чин гүрний эрх баригсад 1733 онд байгуулсан бөгөөд Засагт хан аймаг, Сайн ноён аймгийг шууд харьяалан захирдаг гэвэл аль хариулт нь зөв бэ? **(2 оноо)**

- A. Ховдын Манж сайдын газар
B. Хүрээний Манж сайдын газар
C. Улиастайн Манж жанжны газар
D. Хаалганы манж сайдын газар
E. Хөх хотын Манж сайдын газар

36. Монголчуудаас Чин гүрэнд залгуулж байсан албыг зөв тохируулна уу? **(2 оноо)**

1. Мал адгуулах
2. Шинэлэхийн жасаа
3. Түнлий номын жасаа
- a. 8 цагаан морь 1 цагаан тэмээ багтана.
b. Манжийн хааны насыг уртасгах ном унших.
c. Дарьгангад байгуулсан.

- A. 1-а, 2-б, 3-с.
B. 1-с, 2-а, 3-б.
C. 1-с, 2-б, 3-а.
D. 1-б, 2-а, 3-с.
E. 1-а, 2-с, 3-б.

37. 1880 онд Улиастайд гарсан Сайн ноён аймгийн цэргийн бослогыг хэн удирдсан бэ? **(1 оноо)**

- A. Чингүнжав
B. Энхтайван
C. Амарсанаа
D. Онолт
E. Аюуш

38. Чин гүрэн Шинэ засгийн бодлогынхоо хүрээнд “Хятад иргэдийг Монголд нүүлгэх товчоо”-г хэдэн онд хаана байгуулсан бэ? **(2 оноо)**

- A. 1906 онд Бээжинд
B. 1907 онд Бээжинд
C. 1906 онд Хүрээнд
D. 1907 онд Хөх хотод
E. 1910 онд Бээжинд

39. оны 12 сарын 29-нд VIII Богд Жавзандамба хутагтыг хаанаар өргөмжлөөд, улсын нийслэлийг хэмээн нэрлэжээ. Нөхнө үү? **(2 оноо)**

- A. 1909, Номын хүрээ
B. 1913, Хутагтын хүрээ
C. 1912, Нийслэл хот
D. 1910, Их хүрээ
E. 1911, Нийслэл хүрээ

40. Богд хаант Монгол улсын Дотоод Хэргийг Бүгд Захиран Шийтгэх Яамны сайд хэн бэ? **(1 оноо)**

- A. Т.Намнансүрэн
B. Чин Ван М.Ханддорж
C. Г.Чагдаржав
D. Да Лам Г.Цэрэнчимэд
E. Д.Бодоо

41. 1915 оны Хиагтын гурван улсын хэлэлцээрт ямар улсууд оролцсон бэ? **(1 оноо)**

- A. Орос, Дундад улс, Монгол
B. Орос, Япон, Дундад улс
C. Хятад, Япон, Монгол
D. Монгол, Орос, Япон
E. Франц, Англи, Монгол

42. Эрдэмтэн Ч.Дандаа дараах ном хэвлэлүүдээс алийг нь бичсэн бэ? **(2 оноо)**

- A. Монгол улсын шинэ түүх
B. Шинэ толь
C. Мандах нарны туяа хэмээх сургаалын бичиг
D. Нийслэл хүрээний сонин бичиг
E. Эрдэнэт толь



43. Монгол Ардын Нам-аас эрхлэн 1920 оны 9-р сараас гаргаж эхэлсэн сонин аль нь вэ?
(2 оноо)
- А. Хувьсгалын үнэн
В. Монголын үнэн
С. Нийслэл хүрээний сонин бичиг
D. Шинэ толь
E. Монголын мэдээ
44. 1921 оны 2 сард Хятадын гэмин цэргийг хөөн зайлуулж, Богдыг хаанд өргөмжилж, засгийн газрыг сэргээн байгуулахдаа Жалханз хутагт Дамдинбазарыг Засгийн газрын тэргүүнээр томилсон хүн аль нь вэ?
(1 оноо)
- А. С.Борисов
В. Сюй Шү Жан
С. Барон Унгерн
D. Чен И
E. С.Магсаржав
45. 1921 оны III сарын 1-3-нд Троицкосавск хотноо болсон хурлаар Монгол Ардын Намын Төв хорооны даргаар хэнийг сонгосон бэ?
(1 оноо)
- А. Д.Бодоо
В. С.Данзан
С. Д.Сүхбаатар
D. Х.Чойболсан
E. Д.Чагдаржав
46. Монгол Ардын Намын VII их хурлын шийдвэрээр 1929 онд байгуулагдсан Феодалын хөрөнгө хураах ажлыг хэн удирдаж байсан бэ?
(1 оноо)
- А. Ж.Лхүмбэ
В. Ө.Бадрах
С. З.Шижээ
D. Х.Чойбалсан
E. П.Гэндэн
47. 1931 онд орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалтыг өөрчилж хэдэн аймаг хэдэн сумтай болгосон бэ?
(2 оноо)
- А. 13 аймаг, 324 сум
В. 4 аймаг, 114 сум
С. 18 аймаг, 360 сум
D. 21 аймаг, 368 сум
E. 5 аймаг, 160 сум
48. Зүүнтний учруулсан хор уршгийг арилгахын тулд 1932 оны зунаас Баруунтны бодлогыг сэргээн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ нь ямар нэртэй байсан бэ?
(2 оноо)
- А. Ардын засгийн бодлого
В. Шинэ засгийн бодлого
С. Монголын хойчийг сайжруулах бодлого
D. Шинэ төрийн бодлого
E. Шинэ эргэлтийн бодлого
49. Дэлхийн II дайны үед Монголчуудын зүгээс Зөвлөлтийн армид танкийн бригад байгуулж өгсөн байдаг. Тэрхүү танкийн бригадын нэр аль нь вэ?
(1 оноо)
- А. Бүхнийг фронтод
В. Монгол ард
С. Найрамдал
D. Хувьсгалт Монгол
E. Ялалт
50. БНМАУ-ын статус квог хадгалах асуудлыг хэлэлцсэн Ялтын бага хурал хэдэн онд болсон бэ?
(1 оноо)
- А. 1946 он
В. 1961 он
С. 1951 он
D. 1959 он
E. 1945 он
51. Улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөө хэдээс хэдэн онд хэрэгжсэн бэ?
(2 оноо)
- А. 1948-1952 он
В. 1944-1948 он
С. 1952-1957 он
D. 1961-1965 он
E. 1966-1970 он



52. 1990 оны ардчилсан хувьсгал түүхэнд хэрхэн тэмдэглэгдэн үлдсэн бэ? **(1 оноо)**

- A. Цагаан морин жилийн ардчилсан хувьсгал
 B. Үндэсний эрх чөлөөний хувьсгал
 C. Капиталист хувьсгал
 D. Ардын ардчилсан хувьсгал
 E. Улаан морин жилийн хувьсгал

53. 1992 онд батлагдсан шинэ үндсэн хуулиар улсын нэрийг хэрхэн нэрлэхээр тогтсон бэ? **(1 оноо)**

- A. Их Монгол улс
 B. Бүгд Найрамдах Монгол Улс
 C. Монгол улс
 D. БНМАУ
 E. Ардчилсан Монгол улс

54. Өмч хувьчлалаар хөдөө орон нутгийн иргэдэд малыг нь үнэ төлбөргүй хувьчилж өгсөн бол 1996 онд хотын иргэдэд алийг нь үнэ төлбөргүй хувьчилж өгсөн бэ? **(1 оноо)**

- A. Орон сууц
 B. Газар
 C. Үйлдвэр
 D. Мал
 E. Банк

55. Их Монгол улс байгуулагдсаны 800-н жилийн ойг хэдэн онд ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлсэн бэ? **(2 оноо)**

- A. 2003 он
 B. 2004 он
 C. 2005 он
 D. 2006 он
 E. 2007 он

56. 2008 онд Бээжингийн олимпын наадмаас Жүдо бөхийн төрлөөр алтан медаль хүртсэн тамирчин хэн бэ? **(1 оноо)**

- A. Н.Түвшинбаяр
 B. Д.Баатаржав
 C. Э.Бадар-Ууган
 D. Х.Цагаанбаатар
 E. О.Гүндэгмаа

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ, ДАРААЛАЛ СЭРГЭЭХ ДААЛГАВАР

Санамж:

- а. Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү?**
б. Зөв хариулт бүр нэг оноотой.

2.1. Дараах дурсгалуудыг хамрах үетэй нь зөв тохируулна уу? **(5 оноо)**

- | | |
|--------------------------|----------------------|
| 1. Норовлингийн суурин | a. Палеолит |
| 2. Могоогийн хадны зураг | b. Мезолит |
| 3. Чандманий соёл | c. Неолит |
| 4. Хойд Цэнхэрийн агуй | d. Хүрэл зэвсгийн үе |
| 5. Хиригсүүрийн соёл | e. Төмрийн түрүү үе |

2.2. Чингис хааны хийсэн тулалдаануудыг болсон газар, тулалдсан аймагтай нь зөв тохируулна уу? **(5 оноо)**

- | | |
|----------------|-----------------|
| 1. Даланбалжуд | a. Татар аймаг |
| 2. Улз гол | b. Жамуха сэцэн |
| 3. Муу өндөр | c. Найман аймаг |
| 4. Наху гүн | d. Хэрэйд аймаг |
| 5. Хүйтэн уул | e. Тайчууд |



2.3. XVII зууны томоохон чуулгануудыг шийдвэрүүдтэй нь зөв тохируулна уу? **(5 оноо)**

- | | |
|----------------------------|--|
| 1. Ар элстэйн чуулган | a. Дөчин Дөрвөн хоёрын Их цаазыг батлав. |
| 2. Долоннуурын чуулган | b. Өвөр Монгол Манжид дагаар оров. |
| 3. Улаан Бураагийн чуулган | c. Халх Манжид дагасны ёслол үйлдэв. |
| 4. Хүрэн бэлчирийн чуулган | d. Халх Манжийг дагах шийдвэр гаргав. |
| 5. Мүгдэний чуулган | e. Халхын баруун, зүүн гарыг эвлэрүүлэх чуулган. |

2.4. XX зууны эхэн үед гарсан ном, сэтгүүл, сонинг гарч эхэлсэн он цагтай нь зөв тохируулна уу? **(5 оноо)**

- | | |
|---------------------------------|-----------------|
| 1. Эрдэнэт толь | a. 1918 он |
| 2. Шинэ толь | b. 1920 он |
| 3. Нийслэл хүрээний сонин бичиг | c. 1915 он |
| 4. Монголын үнэн | d. 1913 он |
| 5. Монгол улсын шастир | e. 1913-1915 он |

